

А.Н.У-ын цаг агаарын таагүй байдал, санхүүгийн зах зээлийн давалгаа, Украины цөричилдөөний улмаас дэлхийн эдийн засаг энэ жил их бартаатай эхэллээ. Үүний үр дүнд 2014 оны 1 сарын дэлхийн өсөлтийн таамаглалыг 3.2 хувь байна гэж төсөөлж байсан бол одоогийн байдлаар 2.8 болж буурсан байна. Хэдийгээр өсөлт жилийн эхнээс суларч эхэлсэн боловч цаашид хурдацтай өсч, дэлхийн ДНБ 2015 онд 3.4 хувь, 2016 3.5 хувь буюу өмнө нь таамаглаж байснаар өсөх хандлагатай байна. 2010 оны Худалдан авах чадварын харьцаанаас үзвэл дэлхийн өсөлт 2013 оны 3.1 хувиас 2014 онд 3.4 хувь, 2015 онд 4.0 хувь, 2016 онд 4.2 хувь байна гэж гаргажээ.

Өндөр орлоготой улсын сэргэлт ирж байна

Өсөлтийн дийлэнхи хувь нь өндөр орлоготой улсуудаас (тухайлбал А.Н.У болон Европ) гарна. Төсвийг нэгтгэж, хөдөлмөрийн зах зээлийн нөхцлийг сайжруулан, эдгээр улсуудын эрэлтийн тогтвортой чөлөөлөлт нь эхний улирлын уян байдлыг даван туулж, өндөр орлоготой ДНБ-ний өсөлт 2013 оны 1.3 хувиас 2014 онд 1.9 хувь, 2015 онд 2.4 хувь, 2016 онд 2.5 хувь болж өсөх хандлагатай байна.

Хөгжиж буй улс орнуудын өсөлт удаашралтай байна

Хөгжиж буй улс орнуудын өсөлт 2014 онд жигд байна. Энэ нь 3 дахь жилдээ үргэлжлэн суурь 5 хувийн өсөлттэй байгааг тэмдэглэж байгаа ба илүү хүндрэлтэй хямралын дараахь дэлхийн эдийн засгийн орчинг тусгаж байна. Жилийн жигд үзүүлэлт нь 2014 оны үйл ажилаагааг далдлан, хөгжиж буй орнуудын өсөлт 2015 онд 5.4 хувь, 2016 онд 5.5 хувь болохыг бататгаж байгаа юм.

Үр дүнд нь эсэргүүцэх хүчийг харуулж байна. Нэг талаас үзэхэд өндөр орлогын өсөлт нь 2013 оныд 40-өөс бага хувьд байсан дэлхийн өсөлтийг 2015 он гэхэд ойролцоогоор 50 хувьд хүргэх ач холбогдолтой салхиар хангах юм. Үүний үр дүнд, өндөр орлоготой импортын эрэлт өнгөрсөн оны 1.9 хувиас 2014 онд 4.2 хувь, 2016 онд 5.0 хувь болтлоо өсч, хөгжиж буй орнуудын экспорт өнгөрсөн оны 3.7 хувьтай харьцуулахад 2016 онд 6.6 хувь болох хандлага байна.

Хөгжиж буй орны өсөлт зарим хэсэгт хүчтэй байж чадахгүй, яагаад гэвэл ихэнхи хөгжиж буй улс орнууд хямралаас бүрэн сэргэж, хүчин чадалдаан ойртож байгаа. Түүнчлэн, дэлхийн санхүүгийн нөхцөл байдал дунд хугацаанд чангарна. Гэвч, Европын бүсээс мэдрэгдэхүйц зээлжилтийн хөнгөрүүлэлт бий болсон тул хэдийн чангарах нь одоогоор тодорхой бүс байна. Бусад өсөлтийн хүчин зүйлсэд Хятад улсын бүтцийн өөрчлөлт, хөгжиж буй орнуудын дунд саармаг бодлогыг аажмаар барих, бараа экспортлогчдын хувьд барааны үнийн тогтвортой байдал болон үнийн бууралт багтаж байгаа юм.

Бүсийн төлөвийн хувилбар

Нийлүүлэлтийн талын саад тотгорт хүчтэй өсөлт мэдрэгдэхгүй, ялангуяа Зүүн Ази, Номхон далайн хэсэг; Латин Америк болон Каррибийн хэсэг; Африкийн Сахар. Энэ бүсийн дийлэнхи эдийн засгууд аль хэдийнэ санхүүгийн хямралаас ангижирсан бөгөөд өсөлт нь хүчин чадалдаан дөхөн ирсэн. Зүүн

Тэргүүн зүйлсийг шилжүүлж, ирээдүйг бүтээн байгуулна

2014 оны 6 дугаар сар

Азийн бүсийн хувьд өсөлт удааширч 2016 онд 7.0 хувь байхаар таамаглаж байна. Латин Америкийн дийлэнхи улс орнууд бүрэн хүчин чадалдаан хүрч ажиллаж байгаа боловч Бразил, Аргентин, Мексик орнуудын гарцыг сайжруулснаар 1.9 хувийн бүсийн өсөлтийг 2016 он гэхэд 3.5 хувь хүртэл хүргэж болохоор төсөөлж байна. Африкийн Сахарын ДНБ-ний өсөлт 2014 оны жигд 4.7 хувиас 2016 он гэхэд 5.1 хувьд аажмаар хүрэхээр таамаглаж байна.

Европ болон Төв Азийн бүтээмж Украйны зөрчилдөөнөөс ихээхэн шалтгаална. Тус бүсийн хөгжиж буй орнуулын өсөлт 2014 онд 2013 оны 3.6 хувиас буурч 2.4 хувьд хүрэх бол 2015, 2016 онуудад 3.7, 4.0 хувиар өсөх хандлагатай байна. Газар зүйн бүсийг (Орос, Польш болон бусад Балтийн тэнгисийн орнууд буюу өндөр орлоготой улсуудыг хамруулан) өргөн хэмжээнд авч үзвэл өсөлт 2014 онд 1.7 хувиас 2016 он гэхэд 3.2 хувь байхаар төсөөлж байна.

Ойрхи Дорнод, Хойд Африк, Өмнөд Африкд өсөлт өндөр байхаар харагдаж байна. Өмнөд Азийн хувьд Энэтхэг улс нь нийлүүлэлтийн хязгаарлалтыг зөөллөх шинэчлэлийг эрчим хүч, дэд бүтцийн салбарт хийснээр гол өсөлтийг авчирна. Бүсийн өсөлт 2013 оны 4.8 хувиас 2014 онд 5.3 хувь, 2015 онд 5.9 хувь, 2016 онд 6.3 хувьд хүрэх таамаглал байна. Ойрхи Дорнодын хувьд өнгөрсөн жилийн өсөлтөөс аажмаар өсч, Иран болон Иракийн нефтийн үйлдвэрлэлийн өсөлт, Египт Иорданы сүүлийн жилүүдийн зөрчилдөөны дараах сэргэн босголтоос хамаарч 2014 онд 1.9 хувь, 2015 онд 3.6 хувь, 2016 онд 3.5 байхаар байна.

Дэлхий нийтийн эрсдэл багассан боловч нөхцөл байдал санхүүгийн зах зээлийн хэлбэлзлээс ихээхэн хамааралтай байна

Дэлхий нийтийн эдийн засагт үзүүлэх өндөр орлоготой орнуудад суурилсан эрсдэл Европ болон А.Н.У-ын хэрэгжүүлсэн хэдийгээр цаашид ихийг хийх шаардлагатай байгаа бүтцийн шинэчлэлийн улмаас дийлэнхи хувь нь байхгүй болсон гэж болно. Өндөр орлогын хүндрэл болон эрсдэл нь ихэнхи тохиолдолд дунд хугацааны байдал буюу төсвийн тогтвортой байдал, зохисгүй мөнгөний бодлогоос (Европ, А.Н.У, Япон) замбараатай гарах, дифляцийн эрсдэл (Европд) болон үйлдвэрлэлийн өсөлтийг эрс нэмэгдүүлэх бүтцийн шинэчлэлийн хэрэгцээ, шаардлагатай холбоотой хүндрэлүүд байдаг.

Өнгөрсөн жилд эрсдлийг эрт таньж, тухайн жилд авч хэрэгжүүлсэн эдийн засгийн зохицуулалтууд нь эмзэг байдлыг бууруулсан тул хөгжиж буй улсуудын богино хугацааны эрсдэл бага дарамт учруулсан юм. Үүнтэй харьцуулахад, Бразил болон Туркийн дотоодын үнэ, цалингийн дарамт өндөр хэвээр байж, урсгал дансны алдагдал өндөр байна. Хэдийгээр богино хугацаанд дэмжиж байгаа боловч хөгжиж буй орны 4 сараас хойшхи уналт нь хэрвээ дотоодын зээл болон эрэлт нь санхүүгийн дотоод урсгалын өсөлтийн хариуд дэндүү түргэн өргөжих тохиолдолд хэд хэдэн эдийн засгийн эмзэг байдлыг хурцатгах магадлалтай юм. Эдгээр эдийн засгуудын өндөрсөгсөн эрсдэл нь бусад улсуудад халдварлах магадлалтай. Суурь шугамаас үзэхэд Украйны асуудал энэ жил цаашид дэврэхгүйгээр намжина болно гэж найдаж байна. Гэхдээ, хэрэв байдал хурцадвал эдгээр нь дэлхий нийтийн найдлагийг доргиож, хөгжиж улс орнуудын өсөлт буурч ДНБ-ний 1 хувьтай тэнцэхүйц хэмжээний өсөлттэй байхаар байна.

Өндөр орлоготой орнуудын мөнгөний бодлогийг хэвийн байдалд оруулах зохицуулалт нь хамгийн зохимжтой хувибар байх боловч зах зээл хэврэг байна. Макро бодлогын түвшинд цаг хугацаа, шилжилтийн үед зах зээлд цаашид цөөнгүй хэлбэлзэл бий болохыг таамаглаж байна.

Хөгжиж буй улс орнууд энэхүү хэлбэлзэлтэй хэрхэн яаж тэмцэх нь тэдний дотоодын эдийн засаг, түүнтэй тэмцэх бодлогын хэр хэмжээнээс шалтгаална. Өнөөдрийн дэлхийн санхүүгийн зөөлөн нөхцөл байдал нь дотоодын эдийн засгийг замбараатай болгох (богинохон) боломжийг олгож байгаа юм. Төсвийн тэнцэл 2007 оноос хойш тогтмол буурсаар ирсэн бөгөөд дийлэнхи хөгжиж буй орнуудийн өрийн түвшин ДНБ-ний 10 буюу түүнээс дээш хувьд хүрсэн.

Өндөр инфляци, өндөр урсгал дансны алдагдалтай дундаж орлоготой орнуудад макро бодлогыг чангатгах шаардлагатай – ялангуяа, үл хөдлөх хөрөнгийн хүүний хувь 0-тэй ойр байгаа тохиолдолд. Бусад газруудад бодлогыг аажмаар чангатгах нь зохистой юм. Олон улс орнууд алдагдлыг аажмаар бууруулж, ялангуяа өрийн үйлчилгээний зардал нэмэгдэх магадлалтай болон бараа экспортлогчдын хувьд засгийн газрын орлого багасах магадлалтай дунд хугацааны орчинд алдагдлыг бууруулах замаар төсвийн нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх зааварчилгааг авсан.

Дунд хугацааны өсөлт бүтцийн шинэчлэлээс гарна

Дэлхий нийтэд санхүүгийн гадаад орчин чангарч, хүндрэх магадлалтай байгаа үед дотоодын үйлдвэрлэл, өрсөлдөх чадвар нь ирээдүйн өсөлтийг авчрах гол тулгуур юм. Хэдийгээр хөгжиж буй орнууд өндөр орлоготой улс орнууд өсөлт, импорт буурсан ч хөгжиж чадахаан харуулсан боловч энэ мэтээр цаашид үргэлжлэхийн тулд тэд хямралын дараахь галыг унтрааж, эрэлтийг удирдах дотоодын шинэчлэлийг бэхжүүлэх шаардлагатай юм.

Зарим улс орнуудын (Хятад, Мексик, Филиппин) идэвхитэй, дэвшилтэт шинэчлэлийн хөтөлбөр болон бусад улс орнуудын (Колумб, Перу) хэрэгжүүлсэн шинэчлэлүүд нь эдгээр улс орнуудыг дэлхийн санхүүгийн сөрөг салхитай тэмцэхэд тусалж байна.

2013 оны 11 дүгээр сард зарласан байгалийн нөөцийн хуваарилалт сайжруулж, эдийн засаг дахь зах зээлийн хөдөлгөөний үүргийг нэмэгдүүлэх шинэчлэлийн төлөвлөгөө нь Хятад улс хандлагыг харууллаа. Гэвч зээлийн өсөлт буурч, санхүүгийн шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар санхүүгийн тогтворгүй байдлыг бууруулах үед эдийн засгийг дахин тэнцвэржүүлэх нь асар том ажил юм. Барилга байгуулалт буурч, байрны үнэ өссөн нь үл хөдлөх хөрөнгийн зах зээл болон зээлдэх салбар нь санаа зовоосон хэсэг болохыг харуулж байна. Ямар ч төрлийн хатуу газардалт Зүүн Ази болон бараа экспортлогчдод мэдрэгдэхүйц хэтрэлтийг авчирна.

Хүснэгт 1.1 Дэлхий нийтийн төлөвийн тойм

(хүүний түвшин болон нефтийн үнийг оруулаагүйгээр өнгөрсөн жилтэй харьцуулсан хувийн өөрчлөлт)

	2012	2013	2014	2015	2016
<i>Дэлхий нийтийн нөхцөл байдал</i>					
Дэлхийн худалдааны хэмжээ (GNFS)	2.7	2.6	4.1	5.2	5.4
Барааны үнэ (ам.доллараар)					
Нефтийн бус бараа	-8.6	-7.2	-2.5	-0.6	0.1
Нефтийн үнэ (1 баррель/ам.доллар) ¹	105.0	104.1	102.8	99.3	98.1
Хөгжиж буй улсууд руу орж буй олон улсын капиталын урсгал (ДНБ-ний %) ²					
Хөгжиж буй улсууд					
Цэвэр капиталын дотоод урсгал	5.2	5.6	5.6	5.4	5.1
Зүүн Ази, Номхон далайн бүс	4.8	6.1	5.9	5.4	5.0
Европ, Төв Ази	7.3	6.9	8.0	8.4	8.0
Латин Америк, Каррибийн тэнгис	5.4	5.9	5.8	5.8	5.5
Ойрхи Дорнод, Хойд Африк	2.3	2.2	1.7	1.8	1.8
Өмнөд Ази	5.6	3.9	4.5	4.5	4.4
Африкийн Сахарын бүс	6.4	5.8	5.2	5.3	5.4
<i>Бодит ДНБ-ний өсөлт</i> ³					
Дэлхий	2.5	2.4	2.8	3.4	3.5
Санах зүйл: Дэлхий (ХАЧХ жин) ⁴	3.2	3.1	3.4	4.0	4.2
Өндөр орлого	1.5	1.3	1.9	2.4	2.5
Европын бүс	-0.6	-0.4	1.1	1.8	1.9
Япон	1.4	1.5	1.3	1.3	1.5
А.Н.У	2.8	1.9	2.1	3.0	3.0
Хөгжиж буй орнууд	4.8	4.8	4.8	5.4	5.5
Зүүн Ази, Номхон далайн бүс	7.4	7.2	7.1	7.1	7.0
Европ, Төв Ази	1.9	3.6	2.4	3.7	4.0
Латин Америк, Каррибийн тэнгис	2.6	2.4	1.9	2.9	3.5
Ойрхи Дорнод, Хойд Африк	0.6	-0.1	1.9	3.6	3.5
Өмнөд Ази	5.0	4.7	5.3	5.9	6.3
Африкийн Сахарын бүс	3.7	4.7	4.7	5.1	5.1

Эх: Дэлхийн банк

Тэмдэглэл: ХАЧХ=Худалдан авах чадварын харьцаа; т=тооцоолол;

т=төсөөлөл

¹ Дубай, Brent, West Texas Интермедиатын энгийн дундаж.

² Энэ удаагийн Дэлхий эдийн засгийн тойм нь ОУВС-ын Төлбөрийн балансын гарын авлагын 6 дахь хэвлэлтийн хэрэгжилтэд үндэслэсэн олон улсын капиталын урсгалыг хэмжих шинэ аргыг танилцуулж байна. Энэ аргачлалыг ашигласнаар хөгжиж буй улс орнуудын капиталын урсгал Төлбөрийн балансын 5 дахь хувилбар болон Дэлхийн банкны Олон улсын өрийн статистикийг нэгтгэн гаргадаг байсан өмнөх ДЭЗТ-д хэвлэгдсэн үзүүлэлтүүдээс 0.5 хувиар өндөр гарч байна.

³ Нийт өсөлтийн түвшинг 2010 оны ДНБ-ний тогтмол жинг ашиглаж тооцсон.

⁴ 2010 оны ХАЧХ-ны жинг ашиглан тооцсон.